



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.12.24 № 03/2441

танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЗТХЯ/20240103134 дугаартай Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар)-ийн үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирсэнтэй холбогдуулан дараах тодруулгын хариуг хүргүүлж байна.

| № | Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга | Захиалагчийн хүргүүлсэн тодруулгын хариу |
|----|---|--|
| 1. | Тендерийн шалгаруулалтад оролцож байгаа Орос компанийн тендерийн баталгааг гаргагч банк нь Монгол Улсын хуулийн дагуу Монгол улсын арилжааны банк руу SWIFT ашиглан илгээх боломжгүй учир ОХУ-ын банканд гаргуулсан тендерийн баталгаагаа Монгол Улсын Төрийн худалдан авах ажиллагааны газраар дамжуулан цахим системд байршуулж болох уу? | Гадаад улсын банкны баталгааг бүртгэх харилцааг Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-аар зохицуулсан бөгөөд журмын 4.3-ын 4.3.1, 4.3.2-т заасны дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан цахим системд илгээнэ. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага журмын 4.3.2-т заасныг хэрэгжүүлэхэд техникийн шийдлээс шалтгаалан цахим системд илгээх боломжгүй бол Төрийн худалдан авах ажиллагааны газарт хандаж, дэмжлэг авах боломжтой. |

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.